



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 01 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоог батлах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Соёлын газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Соёлын газрын орон тооны хязгаарыг 5 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Соёлын газар /Г.Нямсамбуу/-т даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/63 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2020 оны
11 дугаар захирамжийн хавсралт

СОЁЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын газар /цаашид "газар" гэх / нь нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, уран сайхны боловсролыг нь дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, үндэсний уламжлалт соёлыг өвлүүлэн эзэмшүүлэх соёлын олон талт үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2.Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Соёлын хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжууд төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол шийдвэр, мөрийн хөтөлбөр энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3.Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4.Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.5.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

1.6.Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.7.Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.8.Газрын даргын дэргэд байгууллагын зорилт үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

Хоёр. Соёлын газрын үүрэг

2.1.Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2.Соёл урлагийн талаар холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Соёл урлагийн газруудад зохиох ажлыг төр засаг нийслэлийн өөрөө удирдах болон төрийн байгууллагын бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах ажилтай хослуулан, нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах.

2.4. Соёлын төв, номын сан, кино театр, музейг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохиож байгаа ажлыг нь уялдуулах, хүн амд үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж чанарт хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгч, ажил сайжруулах арга хэмжээг цаг хугацаанд нь авч байх.

2.5. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад хуулийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудтай / өмчийн хэлбэр үл харгалзан / хамтран ажиллах.

2.6. Соёлын байгууллагын ажилтнуудыг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, тэдний хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах, мэргэжил боловсролыг нь дээшлүүлж ажлын арга барилыг боловсронгуй болгохтой холбогдсон арга зүйн сургалт, семинар зохион байгуулах.

2.7. Ардын уламжлалт соёл, ёс заншлыг түгээн уламжлуулах, энэ ажилд соёл урлагийн ажилтнууд, ардын авъяастнуудыг зохион байгуулалттай оролцуулах.

2.8. Нийтийг хамарсан урлаг уран сайхны хөдөлгөөнийг бүх талаар дэмжин хөгжүүлэх урлагийн наадам, уралдаан тэмцээн, соёл урлагийн баяр, өдрүүдийг зохион байгуулах.

2.9. Нийслэл, дүүрэг, байгууллагын хамгаалалтад байгаа түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулан зохион байгуулах.

2.10. Соёл урлагийг хөгжүүлэх, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий уран бүтээлийн эвлэл холбоод, үүсгэл санаачилгын байгууллагатай хамтран ажиллах.

2.11. Соёл урлагийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах.

2.12. Нийслэл хотын гудамж талбайн чимэглэл, өргөн олныг хамарсан баяр, ёслолын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах.

2.13. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

2.14. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.15. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

Гурав. Соёлын газрын эрх

3.1. Соёл урлагийн ажил үйлчилгээтэй холбоотой асуудлаар албан байгууллага, хувь хүмүүсийн ажлыг зааварчлах, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, мэдээ тайлан гаргуулах.

3.2. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилох, томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.3. Соёлын төлбөрт үйлчилгээ эрхлэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд холбогдох журмын дагуу зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

3.4. Соёл урлагийн талаар гадаад орны холбогдох байгууллагуудтай нийслэлийн удирдлагын зөвшөөрснөөр хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулан хэрэгжүүлэх.

3.5. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.6. Харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

3.7. Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж, тайлагнах.

3.8. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.